

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Баянхонгор-Тохижилт үйлчилгээ ОНӨТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2026/134/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Баянхонгор хот

2026

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор:	Б.Мөнхбат
Утас: 99007576	Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер	М.Алтантуяа
Утас: 99061829	Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
Аудитор	Д.Оюун-Эрдэнэ
Утас: 88916603	Цахим хаяг: oyun-erdenede@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
4. АУДИТЫН ТАЙЛАН	19
4.1 Ерөнхий зүйл.....	19
4.2 Материаллаг байдал	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	20
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	21
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНӨТҮГ	Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

**БАЯНХОНГОР ТОХИЖИЛТ
ҮЙЛЧИЛГЭЭ ОНӨТҮГ-ЫН
ДАРГА Т.ОТГОНБААТАР ТАНАА**

2026.02.25 № 2/95
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Баянхонгор-Тохижилт үйлчилгээ ОНӨТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Баянхонгор аймгийн Баянхонгор Тохижилт үйлчилгээ ОНӨТҮГ-ын санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буулгах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Тайлант 2025 онд 2,685,172.2 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 2,634,466.1 мянган төгрөгийн санхүүжилт, өөрийн үндсэн үйл ажиллагааны орлогоос 5,557.4 мянган төгрөг нийт 2,640,023.5 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,619,172.6 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 20,850.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд дараах тушаал шийдвэрийн дагуу үнэ төлбөргүй шилжиж ирсэн үндсэн хөрөнгө, бараа материалыг хүлээн авч бүртгэж тайлагнасан байна.

- Баянхонгор аймгийн ИТХ-ын хуралдааны 2025 оны "Хөрөнгөд эзэмшигч тогтоох тухай" 5/05 дугаар тогтоол, 10/77 дугаар тогтоолоор 1,722,831.8 мянган төгрөгийн авто зам, ногоон байгууламж, явган хүний зам, автомашин, гэрлэн дохио, гэрэлт хөшөө, хүүхдийн тоглоомын талбайн тоглоом, дасгалын төхөөрөмж, сагсны талбай, шийт, сүүдрэвч, хогийн сав зэрэг хөрөнгүүд;

- Баянхонгор аймгийн ИТХ-ын хуралдааны 2025 оны "Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай" 10/79 дугаар тогтоолоор 1,169,646.0 мянган төгрөгийн нийтийн эзэмшлийн зам, гудамж, талбайн гэрэлтүүлэг, түүнтэй холбогдох хөрөнгүүд;

- Баянхонгор сумын ИТХ-ын хуралдааны 2025 "ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгөд өмчлөгч тогтоох тухай" 7/43 дугаар тогтоолоор 489,566.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 7,905.5 мянган төгрөгийн бараа материал;

- Баянхонгор аймгийн ИТХ-ын даргын "Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай" 04 дугаар захирамж, 59 дугаар захирамжаар 18,290.0 мянган төгрөгийн мотоцикл, суудлын авто машин;

- Баянхонгор аймгийн Засаг даргын 2025 оны "Онцгой комиссын дотоодын хүмүүнлэгийн бараа материал хуваарилан олгох тухай" А/223 дугаар захирамжаар 35,314.5 мянган төгрөгийн бараа материал тус тус хүлээн авсан байна.

Бусад асуудал

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Б.МӨНХБАТ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>392,640,436.73</u>	<u>542,872,576.73</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	392,640,436.73	542,872,576.73
351	Түүхий эд материал	23,371,672.73	30,933,172.73
35110	Тусгай зориулалттай материал	23,371,672.73	30,933,172.73
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	6,165,864.00	2,165,964.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	31,050,200.00	18,586,450.00
354	Хангамжийн материал	332,052,700.00	491,186,990.00
35410	Бичиг хэргийн материал	11,123,100.00	11,702,600.00
35420	Аж ахуйн материал	162,577,060.00	250,660,850.00
35430	Сэлбэг хэрэгсэл	14,684,540.00	28,280,540.00
35450	Барилгын засварын материал	970,000.00	970,000.00
35470	Бусад хангамжийн материал	142,698,000.00	199,573,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>20,224,108,250.61</u>	<u>21,161,764,789.50</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	20,224,108,250.61	21,161,764,789.50
392	Биет хөрөнгө	12,519,848,250.61	13,847,504,789.50
39201	Барилга, байгууламж, орон сууц	542,456,204.54	542,456,204.54
39202	Хуримтлагдсан элэгдэл	(510,025,942.64)	(511,933,605.08)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	441,594,000.00	654,075,080.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(203,817,833.63)	(276,579,645.68)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	505,955,085.00	594,250,038.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(364,613,722.32)	(396,105,007.38)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,688,200.00	16,440,200.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,313,700.00)	(11,146,922.22)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	800,000.00	276,560,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	23,236,904,612.59	25,990,815,560.49
39215	Хуримтлагдсан элэгдэл	(11,133,778,652.93)	(13,031,327,113.17)
393	Биет бус хөрөнгө	7,704,260,000.00	7,314,260,000.00
39301	Програм хангамж	770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(770,000.00)	(770,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	7,704,260,000.00	7,314,260,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>20,616,748,687.34</u>	<u>21,704,637,366.23</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>200,000.00</u>	<u>6,655,852.10</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	200,000.00	6,655,852.10
413	Өглөг	200,000.00	6,655,852.10
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	634,367.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	5,921,485.10
4136	Бусад өглөг	200,000.00	100,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	200,000.00	100,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>20,616,548,687.34</u>	<u>21,697,981,514.13</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	20,616,548,687.34	21,697,981,514.13
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	9,921,113,052.00	9,531,113,052.00
51101	Өмч: - төрийн	9,921,113,052.00	9,531,113,052.00

Баянхонгор аймгийн Баянхонгор-Тохижилт үйлчилгээ ОНӨТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

512	Хуримтлагдсан үр дүн	10,695,435,635.34	12,166,868,462.13
51210	Өмнөх үеийн үр дүн	10,695,435,635.34	10,695,435,635.34
51220	Тайлант үеийн үр дүн	-	1,471,432,826.79
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	20,616,748,687.34	21,704,637,366.23

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,134,147,775.00	6,181,116,154.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,258,943,675.00	3,539,316,654.10
120	Нийтлэг татварын бус орлого	1,258,943,675.00	3,539,316,654.10
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,677,765.00	5,557,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,677,765.00	5,557,400.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,251,265,910.00	3,533,759,254.10
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,875,204,100.00	2,641,799,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	7,333,400.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,700,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	4,633,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,875,204,100.00	2,634,466,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,875,204,100.00	2,634,466,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,405,105,369.00	4,705,824,775.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,405,105,369.00	4,705,824,775.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,381,132,434.32	4,682,973,832.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,364,040,229.00	1,846,498,665.91
210101	Үндсэн цалин	758,616,229.00	886,885,850.91
210102	Нэмэгдэл	419,000,000.00	762,729,098.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	121,823,000.00	142,358,101.00
210104	Урамшуулал	24,806,400.00	-
210105	Гэрээт ажлын хөлс	39,794,600.00	54,525,616.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	191,614,426.91	233,350,300.00
210201	Тэтгэврийн даатгал	135,402,426.91	158,678,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	14,686,600.00	18,668,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,920,900.00	9,334,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	6,920,900.00	9,334,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	27,683,600.00	37,336,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	174,849,456.54	220,722,977.00
210301	Гэрэл, цахилгаан	171,679,652.54	217,057,073.00
210303	Цэвэр, бохир ус	3,169,804.00	3,665,904.00
2104	Хангамж, бараа материалын зардал	37,678,820.00	46,269,575.10
210401	Бичиг хэрэг	3,431,560.00	2,492,000.00
210402	Тээвэр, шатахуун	21,997,344.00	32,263,485.10
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,360,516.00	2,516,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,021,400.00	2,748,490.00
210408	Бараа материал акалсны зардал	2,668,000.00	5,049,600.00
2105	Нормативт зардал	11,979,000.00	13,030,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,979,000.00	13,030,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	43,501,856.00	120,197,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,253,000.00	5,048,000.00

**Баянхонгор аймгийн Баянхонгор-Тохижилт үйлчилгээ ОНӨТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,613,500.00	4,516,000.00
210604	Урсгал засвар	35,635,356.00	110,633,200.00
2107	Томилолт, зочны зардал	910,000.00	780,000.00
210702	Дотоод албан томилолт	910,000.00	780,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,805,728.00	77,514,982.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,070,764.00	75,165,718.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	270,864.00	941,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	304,500.00	408,264.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	159,600.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,539,752,917.87	2,124,610,132.93
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,783,800.00	52,291,050.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,519,969,117.87	2,072,319,082.93
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,972,934.68	22,850,942.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,656,300.00	2,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	1,300,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	13,656,300.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,000,000.00	700,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,316,634.68	20,850,942.09
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,316,634.68	20,850,942.09
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(1,270,957,594.00)	1,475,291,379.07
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,687,931.19	3,858,552.28
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	3,687,931.19	3,858,552.28
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(3,687,931.19)	(3,858,552.28)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(1,274,645,525.2)	1,471,432,826.79


2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,882,881,865.00	2,647,356,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,677,765.00	5,557,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,677,765.00	5,557,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,677,765.00	5,557,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,677,765.00	5,557,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,875,204,100.00	2,641,799,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	7,333,400.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,700,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	4,633,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,875,204,100.00	2,634,466,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,875,204,100.00	2,634,466,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,880,081,865.00	2,647,356,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,880,081,865.00	2,647,356,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,856,108,930.32	2,623,774,457.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,364,040,229.00	1,846,064,298.91
210101	Үндсэн цалин	758,616,229.00	886,451,483.91
210102	Нэмэгдэл	419,000,000.00	762,729,098.00



**Баянхонгор аймгийн Баянхонгор-Тохижилт үйлчилгээ ОНӨТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210103	Унаа хоолны хөнгөлөлт	121,823,000.00	142,358,101.00
210104	Урамшуулал	24,806,400.00	-
210105	Гэрээт ажлын хөлс	39,794,600.00	54,525,616.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	192,195,266.78	233,350,300.00
210201	Тэтгэврийн даатгал	135,983,266.78	158,678,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	14,686,600.00	18,668,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,920,900.00	9,334,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	6,920,900.00	9,334,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	27,683,600.00	37,336,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	174,849,456.54	220,722,977.00
210301	Гэрэл, цахилгаан	171,679,652.54	217,057,073.00
210303	Цэвэр, бохир ус	3,169,804.00	3,665,904.00
2104	Хангамж, бараа материалын зардал	36,920,420.00	39,927,000.00
210401	Бичиг хэрэг	3,299,560.00	2,177,000.00
210402	Тээвэр, шатахуун	21,997,344.00	26,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,360,516.00	2,300,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	1,100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,063,000.00	7,850,000.00
2105	Нормативт зардал	11,979,000.00	28,030,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,979,000.00	28,030,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	35,998,830.00	157,219,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,000,000.00	11,199,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,808,000.00	9,804,500.00
210604	Урсгал засвар	23,190,830.00	136,215,600.00
2107	Томилолт, зочны зардал	910,000.00	780,000.00
210702	Дотоод албан томилолт	910,000.00	780,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,715,728.00	66,222,882.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,980,764.00	63,659,618.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	270,864.00	955,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	304,500.00	408,264.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	159,600.00	200,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,500,000.00	31,457,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,500,000.00	31,457,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,972,934.68	23,582,442.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,656,300.00	2,731,500.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	2,731,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	13,656,300.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,000,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,316,634.68	20,850,942.09
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,316,634.68	20,850,942.09
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	2,800,000.00	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,800,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,800,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	2,800,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,800,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(2,800,000.00)	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

							/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	
C01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	2,216,853,052.00	1,885,313.59	5,509,725,906.80	00.00	7,728,464,272.39	
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,216,853,052.00	1,885,313.59	5,509,725,906.80	00.00	7,728,464,272.39	
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	(1,885,313.59)	00.00	00.00	00.00	
C07	Тайлант үеийн үр дүн	7,696,300,000.00	00.00	22,120,669.37	00.00	7,718,420,669.37	
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,921,113,052.00	00.00	10,695,435,635.34	00.00	20,616,548,687.34	
D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	9,921,113,052.00	00.00	10,695,435,635.34	00.00	20,616,548,687.34	
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,921,113,052.00	00.00	10,695,435,635.34	00.00	20,616,548,687.34	
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	(390,000,000.00)	00.00	00.00	00.00	(390,000,000.00)	
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,471,432,826.79	00.00	1,471,432,826.79	
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,531,113,052.00	00.00	12,166,868,462.13	00.00	21,697,981,514.13	

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

					/төгрөгөөр/
Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,681,422,200.00	2,619,172,557.91	62,249,642.09	97.7	
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,676,422,200.00	2,613,615,157.91	62,807,042.09	97.7	
Орон нутгийн төсвөөс	2,676,422,200.00	2,613,615,157.91	62,807,042.09	97.7	
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,000,000.00	5,557,400.00	(557,400.00)	111.1	
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	5,557,400.00	(557,400.00)	111.1	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,685,172,200.00	2,619,172,557.91	65,999,642.09	97.5	
УРСГАЛ ЗАРДАЛ	2,685,172,200.00	2,619,172,557.91	65,999,642.09	97.5	
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,680,172,200.00	2,616,441,057.91	63,731,142.09	97.6	
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,866,802,200.00	1,846,064,298.91	20,737,901.09	98.9	
Үндсэн цалин	895,660,200.00	886,451,483.91	9,208,716.09	99.0	
Нэмэгдэл	765,678,000.00	762,729,098.00	2,948,902.00	99.6	
Унаа хоолны хөнгөлөлт	150,938,000.00	142,358,101.00	8,579,899.00	94.3	
Гэрээт ажлын хөлс	54,526,000.00	54,525,616.00	384.00	100.0	
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	233,350,300.00	233,350,300.00	-	100.0	
Тэтгэврийн даатгал	158,678,300.00	158,678,300.00	-	100.0	
Тэтгэмжийн даатгал	18,668,000.00	18,668,000.00	-	100.0	
ҮОМШӨ-ний даатгал	9,334,000.00	9,334,000.00	-	100.0	

**Баянхонгор аймгийн Баянхонгор-Тохижилт үйлчилгээ ОНӨТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Ажилгүйдлийн даатгал	9,334,000.00	9,334,000.00	-	100.0
Эрүүл мэндийн даатгал	37,336,000.00	37,336,000.00	-	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	259,720,000.00	220,722,977.00	38,997,023.00	85.0
Гэрэл, цахилгаан	255,000,000.00	217,057,073.00	37,942,927.00	85.1
Цэвэр, бохир ус	4,720,000.00	3,665,904.00	1,054,096.00	77.7
Хангамж, бараа материалын зардал	42,200,000.00	39,927,000.00	2,273,000.00	94.6
Бичиг хэрэг	2,500,000.00	2,177,000.00	323,000.00	87.1
Тээвэр, шатахуун	28,000,000.00	26,500,000.00	1,500,000.00	94.6
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,500,000.00	2,300,000.00	200,000.00	92.0
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	1,100,000.00	100,000.00	91.7
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,000,000.00	7,850,000.00	150,000.00	98.1
Нормативт зардал	28,040,000.00	28,030,000.00	10,000.00	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	28,040,000.00	28,030,000.00	10,000.00	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	153,986,700.00	152,586,200.00	1,400,500.00	99.1
Багаж, техник, хэрэгсэл	11,400,000.00	11,199,500.00	200,500.00	98.2
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	10,004,500.00	9,804,500.00	200,000.00	98.0
Урсгал засвар	132,582,200.00	131,582,200.00	1,000,000.00	99.2
Томилолт, зочны зардал	1,000,000.00	780,000.00	220,000.00	78.0
Дотоод албан томилолт	1,000,000.00	780,000.00	220,000.00	78.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	63,573,000.00	63,522,882.00	50,118.00	99.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	61,000,000.00	60,959,618.00	40,382.00	99.9
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	955,000.00	955,000.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн оношлогоо	418,000.00	408,264.00	9,736.00	97.7
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	200,000.00	200,000.00	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	31,500,000.00	31,457,400.00	42,600.00	99.9
Бараа үйлчилгээний бусад зардал	31,500,000.00	31,457,400.00	42,600.00	99.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,000,000.00	2,731,500.00	2,268,500.00	54.6
Бусад урсгал шилжүүлэг	5,000,000.00	2,731,500.00	2,268,500.00	54.6
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,000,000.00	2,731,500.00	2,268,500.00	54.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-		

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/ Гүйцэтгэл
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,333,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,333,400.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,700,000.00

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,633,400.00
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,333,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,333,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,633,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,633,400.00
210604	Урсгал засвар	4,633,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,700,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,700,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор Тохижилт үйлчилгээ ОНӨТҮГ нь нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээ, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, мод үржүүлэг ойжуулалт, ойн зурвасын харуул хамгаалалт, хотын доторх нийтийн эзэмшлийн хөшөө, түүх соёлын дурсгалт зүйлийн арчилгаа, засвар үйлчилгээ, парк, цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалт, хамгаалалт, усан оргилуур усан толио зэрэг нийтийн эзэмшлийн усан байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээ, гэрлэн дохионы засвар үйлчилгээ, арчлалт хамгаалалтыг ханган ажиллах чиг үүрэгтэй байна.

Тус байгууллага нь авто зам, явган зам, дугуйн зам, төв талбай, Жаргалант, Мазаалай, Гурван бүс цогцолбор, Гон Гандан дэдлэн хийд, Хэлмэгдэгсэд болон Ахмадын цэцэрлэгт хүрээлэнгүүд, Эрдэнэмандал хайрхан болон хуучин бирж, Мазаалай паркийн авто зогсоол, хотын доторх хайс хамгаалалт, тусгаарлах ойн зурвасууд, бш гэрлэн дохио болон бусад нийтийн эдэлбэр газруудын гэрэлтүүлгийн засвар, цэвэрлэгээ үйлчилгээ, арчилгаа хамгаалалт, зам талбайн цэцэгжүүлэлт, зүлэгжүүлэлт, нийтийн эдэлбэр газар, замын тусгаарлах зурвасын мод, бут сөөгийн нөхөн тариалалт зэрэг үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Баянхонгор аймгийн Тохижилт үйлчилгээ ОНӨТҮГ нь дотоод аудитын нэгж байгүй бөгөөд дотоод аудитын чиг үүргийг аймгийн Санхүүгийн хяналт дотоод аудитын газар хэрэгжүүлдэг бөгөөд тайлант онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор Тохижилт үйлчилгээ ОНӨТҮГ нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн загвараар бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь аймгийн СТСХ-ээс баталсан “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн жишиг баримт бичиг”-ийг санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажилласан байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор Тохижилт үйлчилгээ ОНӨТҮГ нь 2025 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын тушаалаар батлагдсан заавар журмууд, УСНББОУС-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,087,888.7 мянган төгрөг буюу 5.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	392,640.44	542,872.58	150,232.14
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	0.0	0.0
Бараа материал	392,640.44	542,872.58	150,232.14
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	20,224,108.25	21,161,764.79	937,656.54
Үндсэн хөрөнгө	32,446,428.10	35,389,627.08	2,943,198.98
Хуримтлагдсан элэгдэл	(12,222,319.85)	(14,227,862.29)	(2,005,542.44)
Нийт хөрөнгө	20,616,748.69	21,704,637.37	1,087,888.68
Өр төлбөр	200.00	6,655.85	6,455.85
Засгийн газрын хувь оролцоо (Эздийн өмч)	20,616,548.69	21,697,981.51	1,081,432.83
Өр төлбөр ба цэвэр	20,616,748.69	21,704,637.37	1,087,888.68

Дээрх хүснэгтээс харахад Баянхонгор Тохижилт үйлчилгээ ОНӨТҮГ-ын 2025 оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо дансад нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 542,872.6 мянган төгрөг болж өмнөх оноос 150,232.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 261,371.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, үйл ажиллагаандаа 236,014.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан, 66,197.1 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, 5,049.6 мянган төгрөгийн бараа материалыг акталж устгасантай холбоотой байна.

Мөн өөрсдийн хүлэмж, мод үржүүлгийн талбайдаа үрээр болон мөчрөөр тарьж ургуулсан 57,775.0 мянган төгрөгийн модны тарьц суулгацыг орлогод авч бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 35,389,627.1 мянган төгрөг болж 2,943,199.0 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь тайлант онд 3,403,834.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг аймаг болон сумын ИТХ-ын хуралдааны тогтоол, аймгийн ИТХ-ын даргын захирамжаар хүлээн авч бүртгэлд тусгасан, 70,635.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж устгасан, 390,000.0 мянган төгрөгийг газар эзэмших эрхийг бусдад шилжүүлсэнтэй холбоотой байна.

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр	Дүн	Тушаал шийдвэр
1	Авто-тээврийн хэрэгсэл	2,790,000.0	Баянхонгор аймгийн ИТХ-ын даргын 2024.02.16-ны өдрийн "Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай" 04 дугаар захирамж
2	Бусад үндсэн хөрөнгө	638,682.2	Баянхонгор аймгийн ИТХ-ын хуралдааны 2025.03.11-ний өдрийн "Үндсэн хөрөнгөд эзэмшигч тогтоох тухай" 5/05 дугаар тогтоол
3	Авто-тээврийн хэрэгсэл	62,191,080.0	
4	Авто-тээврийн хэрэгсэл	15,500,000.0	Баянхонгор аймгийн ИТХ-ын даргын 2025.07.01-ний өдрийн "Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай" 59 дугаар захирамж
5	Тавилга, аж ахуйн эд хогшил	3,500,000.0	Баянхонгор аймгийн ИТХ-ын хуралдааны 2025.12.01-ний өдрийн "Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай" 9/67 дугаар тогтоол
6	Бусад үндсэн хөрөнгө	1,169,646.0	Баянхонгор аймгийн ИТХ-ын хуралдааны 2025.12.25-ны өдрийн "Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай" 10/79 дугаар тогтоол
7	Авто-тээврийн хэрэгсэл	33,000,000.0	Баянхонгор сумын ИТХ-ын хуралдааны 2025.12.19-ний өдрийн "ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгөд өмчлөгч тогтоох тухай" 7/43 дугаар тогтоол
8	Машин тоног төхөөрөмж(компьютер)	38,225.0	
9	усад үндсэн хөрөнгө	418,341.4	
10	Авто-тээврийн хэрэгсэл	99,000,000.0	Баянхонгор аймгийн ИТХ-ын хуралдааны 2025.12.25-ны өдрийн "Хөрөнгөд эзэмшигч тогтоох тухай" 10/77 дугаар тогтоол
11	Машин тоног төхөөрөмж(компьютер)	59,999,953.0	
12	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	275,760,000.0	
13	Бусад үндсэн хөрөнгө	578,198.6	
	НИЙТ ДҮН	3,403,834,174.1	

Тайлант онд 6,655.9 мянган төгрөгийн өглөгтэй ажилласан байна. Үүнд:

- Тээвэр шатахууны өглөг 5,743.5 мянган төгрөг - тайлант онд тээвэр, шатахууны зардалд 28,000.0 мянган төгрөг төсөвлөгдөж, 26,500.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Нийт 32,243.5 мянган төгрөгийн түлш, шатахуун, тос тосолгооны материал худалдан авч үйл ажиллагаандаа зарцуулсан нь анхан шатны баримтаар нотлогдож байгаа бөгөөд тус зардлын төсвийг 4,243.5 мянган төгрөгөөр хэтрүүлэн зээлээр худалдан авалт хийж зарцуулсантай холбоотойгоор оны эцэст өртэй гарсан байна. Мөн тайлант онд түлш, шатахууны үнэ нэмэгдсэн, тус байгууллагад мотоцикль, олон үйлдэлт трактор, соната-7 суудлын авто машин, авто вишк кран, Бонго зэрэг тээврийн хэрэгсэл нэмэгдсэн нь өглөг үүсэхэд нөлөөлсөн байна.
- Үйлдвэрчний эвлэлийн татварын өглөг 634.4 мянган төгрөг - энэ нь тухайн гүйлгээ буцсантай холбоотойгоор дутуу төлөлт үүссэн байна.
- Интернэтийн төлбөр 178.0 мянган төгрөг, хог хаягдлын хураамж 100.0 мянган төгрөг – эдгээр зардлуудын зарцуулах эрхийг 12 дугаар сард нээж өгөөгүйтэй холбоотойгоор өр үүссэн байна.

Дээрх өр төлбөрүүдийг бэлтгэн нийлүүлэгч, байгууллага тус бүрээр тооцоо нийлж актаар баталгаажуулсан, мөн Баянхонгор сумын Санхүү, төрийн сантай тооцоо нийлсэн акт үйлдсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 21,698.0 мянган төгрөг болж 1,081,432.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Тус байгууллага нь “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн Acolous санхүүгийн программыг 2014 оноос хойш ашиглаж байгаа бөгөөд 770.0 мянган төгрөгийн өртөгтэй, 770.0 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, ашиглалтын байдал хэвийн. Программ хангамжтай холбоотойгоор тайлант онд программын шинэчлэлийн төлбөрт 737.0 мянган төгрөг урсгал зардлын төсвөөс зарцуулсан байна.

Газар эзэмших, ашиглах эрхийн байдал

Тус байгууллагад 292,650 мкв талбай бүхий эзэмших эрхтэй нийт 5 газартай. Үүнээс, 4 нь музей, түүх, соёлын дурсгалт газар байна. Тус газрууд нь үндсэн хөрөнгийн бүртгэл болон цахим санд (egazar.gov.mn)-д бүртгэлтэй байна.

Тайлант онд 15,600 мкв талбайтай музей, түүх, соёлын дурсгалт газрыг Баянхонгор аймгийн ИТХ-ын хуралдааны 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн "Эзэмшлийн газар балансаас балансад шилжүүлэх тухай" 6/09 дугаар тогтоол, Баянхонгор аймгийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/272 дугаар захирамжаар Баянхонгор аймгийн түүх угсаатны зүй - байгалийн музейд шилжүүлсэн байна.

Байгууллагын оноосон нэр, түүний хэрэглээ

Тус байгууллагын оноосон нэр улсын бүртгэлийн гэрчилгээ, албан бланкны толгойд “Баянхонгор аймгийн Баянхонгор тохижилт үйлчилгээ ОНӨААТ үйлдвэрийн газар” нэрээр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

Баянхонгор аймгийн ИТХ-ын хуралдааны 2022 оны 09 дүгээр сарын 16-ны

өдрийн “Баянхонгор-Тохижилт үйлчилгээ” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар болгон өөрчлөн байгуулж, дүрэм батлах тухай” 10/36 дугаар тогтоолоор оноосон нэрэнд өөрчлөлт оруулсан байна. Тус тогтоолын дагуу 2022 онд УБЕГ-т нэр солих хүсэлт гаргасан боловч “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд улсын төсөвт үйлдвэрийн газар орон нутгийн өмчит байх тухай хуулийн зохицуулалт байхгүй тул улсын төсөвт үйлдвэрийн газар гэсэн хэлбэрээр улсын бүртгэлд бүртгүүлнэ үү” гэсэн хариуг ирүүлсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 2,096,683.3 мянган төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 6,300.0 мянган төгрөг, нийт 2,102,983.3 мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийг 447,986.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн орон нутгийн төсвөөс 2,550,970.0 мянган төгрөгөөр санхүүжихээр баталсан байна.

Тайлант онд Баянхонгор сумын ИТХ-ын хуралдааны 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 5/30 дугаар захирамжаар зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 134,202.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн орон нутгийн төсвөөс 2,680,172.2 мянган төгрөг, өөрийн орлогын эх үүсвэрээр 5,000.0 мянган төгрөг, нийт 2,685,172.2 мянган төгрөгөөр санхүүжихээр төсөвт тодотгол хийж өөрчилсөн байна. Тус төсвийн тодотголоор гэрэл цахилгааны зардлыг 35,000.0 мянга, урсгал засварын зардлыг 97,582.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд орон нутгийн төсвөөс 2,634,46661 мянган төгрөгийн санхүүжилт, өөрийн үндсэн үйл ажиллагааны орлогоос 5,557.4 мянган төгрөг нийт 2,640,023.5 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж урсгал үйл ажиллагаанд 2,619,172.6 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 20,850.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт (хувь)
1	71502 Хот байгуулалт тохижилт	2,685,172.2	2,619,172.6	65,999.6	97.5
1.1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	2,648,672.2	2,584,983.7	63,688.5	97.6
1.2	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал, дэмжлэг	5,000.0	2,731.5	2,268.5	54.6
1.3	81701 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардал	31,500.0	31,457.4	42.6	99.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Өөрийн орлого

Тус байгууллага нь 2025 онд 5,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэх төлөвлөгөөтэй ажилласан ба гүйцэтгэлээр 5,557.4 мянган төгрөг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 111.1 хувьтай биелүүлсэн байна. “Мазаалай” цэцэрлэгт хүрээлэнд худалдаа, үйлчилгээ, тоглоомын зориулалтаар талбай түрээслүүлж 5,145.0 мянган төгрөг, хохирлын 307.4 мянган төгрөг, тендерийн орлого 105.0 мянган төгрөгийг төвлөрүүлж, тус орлогыг урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна.

Тус байгууллагын санхүүгийн бүртгэл тайланд өмч нь орон нутгийн өмчит, орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын хэлбэртэй байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар шагналын 2,700.0 мянган төгрөг, байгууллагын 2025 оны А/19 тоот тушаалаар батлагдсан “Нийтийн эзэмшлийн эд хөрөнгөд учруулсан хохирлыг барагдуулах тухай журам”-ын дагуу төвлөрүүлсэн өөрийн орлогын 4,633.4 мянган төгрөг, нийт 7,33.4 мянган төгрөгийн санхүүжилт төвлөрснийг хууль тогтоомжийн дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

1. Байгууллагын орон тооны цомхотгол: Байгууллагын даргын 2025 оны 01 дугаар сарын 02-ны өдрийн “Байгууллагын бүтэц, орон тоо, цалингийн сан тогтоох тухай” А/01 дугаар тушаалаар байгууллагын дарга, менежер, захиргаа удирдлагын хэлтэс, ногоон байгууламжийн алба, тохижилт үйлчилгээ, техникийн алба, нийтийн үйлчилгээний алба гэсэн зохион байгуулалтын бүтэцтэйгээр, үндсэн 74, гэрээт 11, нийт 85 орон тоотой ажиллахаар төлөвлөн баталсан байна. Тайлант онд 69-82 орон тоотойгоор, 4 дүгээр сараас 10 дугаар сар хүртэл гэрээт ажилтантай ажилласан байна.

Ажилтныг томилох, чөлөөлөхдөө байгууллагын даргын тушаал, шийдвэрийг үндэслэдэг бөгөөд 2025 онд бүтэц орон тоог өөрчлөхтэй холбоотой ямар нэгэн тушаал, шийдвэр гараагүй, орон тооны цомхотгол хийгдээгүй байна.

2. Унаа, хоолны хөнгөлөлт (2100103)-ийн зардал: Байгууллагын хамтын гэрээний 2.8 дах заалтыг үндэслэн даргын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 тоот тушаалаар хоолны хөнгөлөлтөд нэг өдрийн 8.0 мянган төгрөгийг ажилтанд тооцож олгосон байна. Тайлант онд хоолны хөнгөлөлтийн зардалд 150,938.0 мянган төгрөг төлөвлөгдөж, 142,358.1 мянган төгрөг буюу зардлын 94.3 хувийг зарцуулсан байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Баянхонгор Тохижилт үйлчилгээ ОНӨТҮГ нь 2025 онд нийт 58,000.0 мянган төгрөгийн дараах 4 нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг худалдан авахаар төлөвлөсөн байна. Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон гүйцэтгэл дараах байдалтай байна.

Бараа, үйлчилгээний нэр төрөл	Хэлбэр	Төсөвт өртөг	Гүйцэтгэгч	Гэрээний дүн	Олгосон санхүүжилт
Цэцэг, хөрс, бордоо худалдан авах	шууд гэрээ	13,071,500.0	"Нарлаг ган хүлэмж" ХХК	13,028,900.0	13,028,900.0
Усалгааны материал худалдан авах	шууд гэрээ	13,928,500.0	"Жаргалант өндөр" ХХК	13,928,500.0	13,928,500.0
Түлш шатахуун	Тендер шалгаруулалт	28,000,000.0	"Шунхлай трейдинг" ХХК	25,464,000.0	26,500,000.0
Элс,бууц худалдан авах	шууд гэрээ	3,000,000.0	"Талын нөмөр" ХХК	3,000,000.0	3,000,000.0
Бараа материал нийлүүлэх	шууд гэрээ	урсгал засварын зардлын төсөв нэмэгдсэн	"Сэлэнгэ менежмент" ХХК	19,498,600.0	19,498,600.0
Бараа материал нийлүүлэх	шууд гэрээ		"Ган утас мөнх" ХХК	тодорхой бус	19,223,600.0
Дүн		58,000,000.0	Дүн		108,864,600.0

Төлөвлөгөөт худалдан авалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, худалдан авалтыг хийсэн байна.

Тайлант онд

1. Түлш шатахуун худалдан авахдаа төсөвт өртгийг 4,243.5 мянган төгрөгөөр хэтрүүлэн худалдан авалт хийсэн нь жилийн эцсээрх байгууллагад төлөх өрийг нэмэгдүүлсэн.
2. Тайлант онд урсгал засварын зардлын төсвийг нэмэгдүүлэн баталсантай холбоотойгоор 32,908.6 мянган төгрөгийн 2 удаагийн худалдан авалтыг 1 компаниас, худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүйгээр шууд гэрээ байгуулан, харьцуулах үнийн саналгүйгээр худалдан авалтыг хийсэн байна.

Тус компанитай байгуулсан гэрээнд гэрээний дүнг тодорхой тусгаагүй, худалдан авах барааны жагсаалтыг хавсралт байдлаар үйлдсэн ч тамга тэмдгээр баталгаажуулаагүй байгааг анхаарч гэрээнд худалдан авах барааны нэр төрөл, үнэ, гэрээний нийт дүн, олгох санхүүжилтийн хуваарийг тодорхой тусгаж байхыг зөвлөв.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 35 дугаар зүйлийн 35.2-т "Гэрээ шууд байгуулах тухай зарлалыг бараа, ажил, үйлчилгээний ерөнхий мэдээллийн хамт цахим системд нийтэлж, энэ хуулийн 54.8-д зааснаар аж ахуй эрхлэгчид хэлэлцээ хийх урилга хүргүүлнэ", 44 дүгээр зүйлийн 44.1-т

"Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолын хавсралтад заасан "Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хууль болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалтуудыг мөрдөж, зөрчлийг давтан гаргахгүйгээр таслан зогсоох талаар албан шаардлага хүргүүлээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Баянхонгор Тохижилт үйлчилгээ ОНӨТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Оюун-Эрдэнэ гүйцэтгэж, үе шатны хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор Тохижилт үйлчилгээ ОНӨТҮГ нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсөв 2,685,172.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 26,851.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуульд хамаарах асуудал байхгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих хуулийн 6.4.5 “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ”-д заасан 52 гүйлгээний 3,046,581.6 мянган төгрөгийн санхүүжилтийн мэдээллийг мэдээлсэн байна.

Шилэн дансны дэлгэрэнгүй мэдээлэл буюу байгууллагын ерөнхий мэдээлэл бүрэн гүйцэт, бусад мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь байршуулж мэдээлсэн байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Даваадорж гүйцэтгэсэн ба аудитаар 182,500.2 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгснийг бүрэн биелүүлсэн талаар тус байгууллагаас 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 71 дугаартай албан бичиг ирүүлэн, санхүүгийн тайлангийн аудитын FAS системд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	182,500.2	1	182,500.2	100%
Нийт дүн	1	182,500.2	1	182,500.2	100%

Баянхонгор тохижилт үйлчилгээний ОНӨТҮГ-ын 2024 онд худалдан авсан усалгааны тоног төхөөрөмжийн худалдан авалт, ашиглалт, Аймгийн ХХААГ-аас олгосон усалгааны системийн ашиглалтыг “Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд улс орон нутгийн төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар шалгахад хамгаалалтын ойн зурвас болон замын тусгаарлах зурвасуудад ашиглагдаж байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж ажилласан эсэхийг орон нутгийн өмчит газруудын гүйцэтгэлийн аудитаар шалгах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 37,152.1 мянган төгрөгийн 2 зөрчил илэрсэнд, зөрчлийг давтан гаргахгүй байх 1 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлээ.

Тус илрүүлсэн зөрчил нь бидний тогтоосон санхүүгийн тайлангийн материаллаг байдлын түвшинд нөлөө үзүүлэхгүй тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1 Зөвлөмж

Түлш шатахууны зардалд батлагдсан төсвийг 4,243.5 мянган төгрөгөөр хэтрүүлэн худалдан авалт хийсэн нь тайлант хугацааны эцэст өр үүсэхэд нөлөөлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг хэтрүүлэн бараа, үйлчилгээ худалдан авахгүй байх, зайлшгүй шаардлагатай тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дээд шатны төсөв захирагчид хүсэлт гарган шийдвэрлүүлсний үндсэн дээр худалдан авалтыг хийх, өр төлбөр үүсгэхгүй үр ашигтай ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.

Аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг нотлох баримтын хамт Төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Түлш шатахууны зардалд батлагдсан төсвийг 4,243.5 мянган төгрөгөөр хэтрүүлэн худалдан авалт хийсэн нь тайлант хугацааны эцэст өр үүсэхэд нөлөөлсөн байна.	1	4,243.5					1	4,243.5
	Дүн	1	4,243.5					1	4,243.5

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
1	Тайлант онд урсгал засварын зардлаас 32,908.6 мянган төгрөгийн арга хэмжээг шууд гэрээ байгуулан худалдан авалтыг хийсэн байна.	1	32,908.6	1	32,908.6	-	-
	Дүн	1	32,908.6	1	32,908.6		

-----oO-----